



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/123

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амгалан дулааны станц ТӨХК-ийн ажилтнуудад олгох “Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2021 оны А/07 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүйд тооцсугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын хэлтэс (П.Зоригоо)-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ

УЛАГЧИГААТАР ХОТ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
Амгалан дулааны станц ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2022 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн
А/123 дугаар тушаалын хавсралт

ХОР СААРМАГЖУУЛАХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Энэхүү журам нь Амгалан дулааны станц ТӨХК-ийн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудад эрүүл ахуйн шаардлага, стандарт хангасан хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн олгож ажилтны эрүүл мэндийг нөхөн сэргээх, хортой хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Нэг. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг хадгалах, олгох, хэрэглээг хянах, тооцоо хийх

1. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалд заасны дагуу “Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл”-д ажилладаг ажилтануудад олгоно.
2. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг тухайн бүтээгдэхүүний шаардлага хангасан байранд эмх цэгцтэй хадгална.
3. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч дараах зааврын дагуу олгоно. Үүнд:
 - 3.1. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг зөвхөн биетээр олгоно. /мөнгөн хэлбэрээр олгохгүй/
 - 3.2. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг батлагдсан нормоор ажлын байранд тухайн өдөрт нь заавал олгоно. /нөхөн олгохгүй/
 - 3.3. Өдрийн ажилтнууд болон 08:00-20:00 цагт ажиллах ээлжийн ажилтнуудад ажлын өдрүүдэд 08:00-09:00 цагийн хооронд олгож гарын үсэг зуруулна. 09:00 цагаас хойш нөхөн олгохгүй.
 - 3.4. 20:00-8:00 цагт буюу шөнийн ээлжинд ажиллах ажилчдад олгох хор саармагжуулах бүтээгдэхүүнийг өдрийн ээлжийн даргад хүний тоогоор нь хүлээлгэн өгч баримтжуулна.
 - 3.5. Бямба, ням гараг, амралт, баяр ёслолын өдөр ажиллах ээлжийн ажилтнуудад олгох хор саармагжуулах бүтээгдэхүүнийг Баасан гарагийн ажлын өдрийн ажиллаж байгаа ээлжийн даргад бямба, ням гараг, амралт, баяр ёслолын өдрүүдэд ажиллах хүний тоогоор нь хүлээлгэн өгч баримтжуулна.
 - 3.6. Хор саармагжуулах бүтээгдэхүүн олгохдоо тухай өдрийн ирцийн мэдээллийг үндэслэн олгоно.
 - 3.7. Хариуцсан ажилтан саармагжуулах бүтээгдэхүүнийг олгосон тухай баримтыг үнэн зөв хөтөлж баримтжуулна.

Хоёр. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг хэрэглэх

1. Ажилтан хор саармагжуулах бүтээгдэхүүнийг зөвхөн ажлын байранд хэрэглэнэ.
2. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг батлагдсан нормоор ажлын байранд тухайн өдөрт нь авна.

Гурав. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг хэрэглээнд хяналт тавих

1. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд хэрэглэж байгаад ХАБЭАИнженер, хариуцсан цехийн дарга, хэсгийн инженер, ээлжийн ажилтнуудад ээлжийн инженер, ээлжийн дарга хяналт тавьж, гарсан зөрчлийг тухай бүр нь арилгах үүрэг хүлээнэ.

Дөрөв. Захиалга өгөх

1. Хор саармагжуулах бүтээгдэхүүний тоог нийлүүлэгч компанид захиалга өгөхдөө сар бүрийн сүүлийн 7 хоногийн Баасан гарагт цех, хэсгүүдийн удирдлагуудаас дараа сард ажиллах хүний тоог авч, станцын хэмжээнд нэгтгэн өгнө.
2. Хор саармагжуулах бүтээгдэхүүний тоог цех хэсгийн удирдлагууд буруу тооцоолон өгсөн тохиолдолд нэгжийн удирдлага хариуцлагыг өөрөө хариуцна.